



**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА
(ЖАЙКА)
БОАЖЯ, НЗДТГ**



**Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах
арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх төсөл (3-р үе шат)**

Мэдээллийн тойм /Дугаар-1/: Төслийн товч танилцуулга (2019 он 2 сар)



Зүүн дээд: Улаанбаатар хотын агаарын бохирдлын байдал (2014 оны 12 сар)

Баруун дээд: УБ хотын өвлийн өглөөний агаарын бохирдол (2018 оны 12 сар)

Зүүн доод: Суурин эх үүсвэрийн утааны хийн хэмжилт (2016 оны 2 сар)

Барууд доод: Зайнаас мэдрэгч төхөөрөмж (RSD) ашигласан автомашины хаягдал утааны хэмжилт (2017 оны 4 сар)

ЖАЙКА Монгол дахь Төлөөлөгчийн газар

Байршил: УБ хот, Сүхбаатар талбай 3, Бодь цамхаг 7 давхар

Шуудангийн хаяг: Central P.O.Box 682, Ulaanbaatar 211213, Mongolia

Утас: 976-11-325939, 312393 Факс: 976-11-310845

<http://www.jica.go.jp/mongolia/index.htm>

Төслийн оффис

Байршил : НАББГ (Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар)

УБ хот, Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж-9, Хангарьд ордон 5 давхар

Утас: 976-11-314876 Факс: 976-11-314876

<http://www.aprd.ub.gov.mn/>

Төслийн үндэслэл

Нийслэл Улаанбаатар хотод түүхий нүүрсний шаталтаас үүдэлтэй агаарын бохирдол тулгамдсан асуудал болж байна. Ялангуяа, өвлийн улиралд халаалтын зорилгоор жилд 6 сая 300 мян.тонн нүүрс шатааснаас тоосонцрын¹ бохирдол улам ихэсдэг. Агаарын бохирдлын голлох эх үүсвэрт гэр хороололд суурьшиж буй 215156 буй өрхийн ахуйн хэрэглээний зуух, төвлөрсөн дулаан хангамжаас алслагдсан сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг дулаанаар хангаж буй төрөл бүрийн хийц, хүчин чадал бүхий 2700 гаруй усан халаалтын зуух, 3 дулааны цахилгаан станц, 1 дулааны станц ордог. Мөн сүүлийн жилүүдэд хотжилт эрчимтэй явагдаж, хүн амын төвлөрөл ихсэхийн зэрэгцээгэр автомашины тоо нэмэгдэж хөдөлгөөнт эх үүсвэрээс үүдэлтэй хаягдал утаа, автозамаас дэгдэх шороо, тоосжилтын хэмжээ ихэссээр байна.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Монгол улсын Засгийн газар Япон улсын Засгийн газарт хүсэлт гаргаснаар ЖАЙКА олон улсын байгууллагын техникийн хамтын ажиллагааны “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг 2010-2013 онд 1-р үе шатыг, 2013-2017 онд 2-р үе шатыг тус тус хэрэгжүүлсэн.

Төслийн хүрээнд Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар (НАББГ), бусад холбогдох байгууллагуудын боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, агаарын чанарын хяналтын тогтолцоо, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр ажилласан. Тухайлбал агаар бохирдуулах эх үүсвэрийн бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, агаар бохирдуулах түгээмэл бодисуудын тархалтын загварчлалыг гаргах, тоосонцор (PM10)-ын химийн найрлагын шинжилгээнд үндэслэн эх үүсвэрийн нөлөөллийг тодорхойлох, агаар бохирдуулах бодисын ялгарлын стандартын төсөл боловсруулах зэрэг олон чиглэлээр техникийн үр чадавх эзэмшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Цаашид агаарын бохирдлыг бууруулахад үр дүнтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах шаардлагатай байна.

Төслийн 1 болон 2-р үе шат

НАББГ болон бусад холбогдох байгууллагын боловсон хүчнийг чадавжуулах, бүтэц тогтолцоог сайжруулахад голлон анхаарч, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг сайжруулах

Агаар, орчны хяналт шинжилгээ, агаар бохирдуулах суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрийн хаягдал утааны хэмжилт, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай техникийн үр чадавхыг эзэмшүүлэх

Төслийн 1 ба 2-р үе шатуудын хүрээнд эзэмшүүлсэн техникийн үр чадавх, агаар орчны хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах



Төслийн 3-р үе шат

НАББГ, төрийн болон нийслэлийн холбогдох байгууллагын ажлын уялдаа, зохион байгуулалтын тогтолцоо, бодит үр дүнтэй арга хэмжээний хэрэгжилтэнд голлон анхаарч, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний чадавхыг сайжруулах

Үндэсний болон нийслэлийн түвшний агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн уялдааг сайжруулах

Техникийн үр чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх (PM тоосонцрын химийн найрлагын дүн шинжилгээ, ресептор модель г.м)

Агаарын бохирдлоос үүдэлтэй иргэдийн эрүүл мэндийн хохирлыг багасгахад чиглэсэн арга хэмжээ (хүйтний болон дулааны улирлын агаарын бохирдлын бүтэц, хүн амын өртөлтийн хэмжээ) -г тодорхойлох чадавхыг бэхжүүлэх

Зураг 1: Төслийн агуулга, техникийн үр чадавх эзэмшүүлэх явц

Энэхүү 2 шаттай хэрэгжүүлсэн төслийн үр дүнд үндэслэн “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 3-р үе шат (цаашид “тус төсөл” гэх)-ыг үргэлжлүүлэх хүсэлтийг 2016 онд МУ-ын Засгийн газраас гаргаснаар Японы Засгийн газар 2018 оны 11 сараас 4,5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болсон.

Эрхэм зорилго, төслийн зорилго, үр дүн

Төслийг Нийслэл болон ЖАЙКА байгууллага харилцан хэлэлцэж, зөвшилцсөнөөр Хүснэгт 1-д үзүүлсэн агуулгаар хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд Хамтрагч тал (Х/Т), Хамтрагч тал-Ажлын хэсэг (Х/Т-АХ) болон ЖАЙКА байгууллагын мэргэжилтнүүдээс бүрдсэн төслийн баг нь хамтран ажиллаж, дараах 6 үр дүнд хүрэх (Хүснэгт 1) юм. Төсөл хэрэгжсэнээр БОАЖЯ, НАББГ бусад холбогдох байгууллагууд нь харилцан зөвшилцсөн арга хэмжээг хэрэгжүүлж, эрхэм зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлнэ.

¹ Тоосонцрын фракцаас хамаарч TSP (нийт хөвөгч тоосонцор), PM10 (фракцын хэмжээ 10 микроноос бага), PM2.5 (фракцын хэмжээ 2.5 микроноос бага) гэж үздэг.

Хүснэгт 1: Эрхэм зорилго, төслийн зорилго, гарах үр дүн

| | |
|-----------------|--|
| Эрхэм зорилго | Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулж, голлох эх үүсвэрүүдээс ялгарах бохирдуулах бодисын ялгарал буурна. |
| Төслийн зорилго | Агаарын бохирдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээний хэрэгжилт, НАББГ, төрийн болон нийслэлийн холбогдох байгууллагын хамтын ажиллагааны тогтолцоог сайжруулахад голлон анхаарч, УБ хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах |
| Үр дүн 1 | Агаар бохирдуулах голлох эх үүсвэрүүдийн ялгарлын хяналт шинжилгээ болон агаар орчны хяналт шинжилгээний чадавхыг сайжруулах. |
| Үр дүн 2 | Улирлаас хамааралтай агаарын бохирдол (ялангуяа PM) -ын бүтцийг тодорхойлох анализ шинжилгээ, үнэлгээний чадавхыг сайжруулах |
| Үр дүн 3 | Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний техникийн үнэлгээ, хэрэгжилтийн бэлтгэл ажлын чадавхыг сайжруулах. |
| Үр дүн 4 | НАББГ, ЦУОШГ зэрэг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээтэй холбоотой /монгол талын/ шийдвэр гаргах түвшний үйл ажиллагааг сайжруулах. |
| Үр дүн 5 | Агаар бохирдуулах томоохон эх үүсвэрт PM, SO ₂ болон NO _x -ийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах. |
| Үр дүн 6 | Үр дүн 1-5-ын биелэлтийг хангахтай холбоотой хууль эрх зүйн орчин, хөрөнгө санхүүжилтийн хувиарлалт, зохицуулалтын механизм (агаар орчны хяналтын суурь тогтолцоо) -ыг боловсронгуй болгож сайжруулах. |

Эрхэм зорилго, төслийн зорилгыг биелүүлэх явцад (1) Орчны агаар болон агаар бохирдуулах бодисын ялгарлын эх үүсвэрүүдийн хяналт шинжилгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн үнэлгээ, (2) Агаарын бохирдлыг бууруулах стратеги, бодлого, шийдвэр, (3) Хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээ, (4) Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт гэсэн 4 шатлал бүхий агаар орчны хяналтын тогтолцоо (Зураг-2) нд тулгуурлан хэрэгжүүлнэ. Тус тогтолцоог бэхжүүлснээр агаарын бохирдлыг бууруулах бодит үр дүнтэй арга хэмжээг сонгож, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Цаашид өмнөх үе шатны хүрээнд эзэмшүүлсэн техникийн үр чадавхыг гүнзгийрүүлж, бататгахын зэрэгцээ үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулж, агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулахыг зорьж ажиллана.

Тус төсөл нь бууруулах арга хэмжээний хэрэгжилтэд голлон анхаарч 1) Гэр хорооллын айл өрхөд сайжруулсан түлш ашиглах, 2) Автомашинны ялгарлыг бууруулах арга хэмжээний загвар төслийг хэрэгжүүлнэ.

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний үр дүнг тодорхойлох, баталгаажуулах зорилгоор сайжруулсан түлшний загвар төслийг 2020 оны 1 сар, мөн 2021 оны 1 сард тус тус агаарын чанарын хэмжилт хийх нөхцөл хангасан гэр хорооллын айл өрхөд сайжруулсан түлшний нийлүүлж, түүний агаар орчинд нөлөөлөх нөлөөлөл, хэрэглээнд гарах өөрчлөлтийг түүхий нүүрс хэрэглэх үетэй харьцуулсан туршилтаар ажлыг зохион байгуулна.

Автотээврийн хэрэгслээс ялгарах хаягдал хийг бууруулах чиглэлээр дараах загвар төслүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Автозамын түгжрэлийг багасгах, гэрлэн дохионы зохицуулалтыг сайжруулах
2. Эко жолоодлогын сургалтын тогтолцоог нэвтрүүлэх /ХБО-нд ээлтэй автомашины хэрэглээ/
3. Дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээс ялгарах тоосонцрыг багасгах (DPF) шүүлтүүрийн үр дүнг баталгаажуулах, улмаар түүний хэрэглээг нэмэгдүүлэх
4. Хүхрийн агууламж багатай шатахууны хэрэглээний орчны нөлөөллийн үнэлгээ г.м.

Төсөл хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт

Төслийн гол Х/Т нь БОАЖЯ, НАББГ бөгөөд үйл ажиллагааны хэрэгжилтийг хариуцаж ажиллана. Х/Т-А/Х нь хамтран хэрэгжүүлэгч холбогдох төр, захиргааны байгууллагаас бүрэлдэнэ. ЖАЙКА -ын япон мэргэжилтний баг нь Зураг 3-д үзүүлсэн байгууллагатай хамтарч, Х/Т болон Х/Т-АХ-т шаардлагатай техникийн зааварчилгаа, зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. НАББГ-ын дарга нь төслийн



Зураг-2 Агаар орчны хяналтын тогтолцоо (шксл)

даргын үүрэг гүйцэтгэж, ерөнхий зохион байгуулалт, хэрэгжилтийг хариуцна. Хамтарсан зохицуулах хороо (ХЗХ) нь төсөлтэй холбоотой шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд ХЗХ-ны хуралдаанд холбогдох төрийн болон нийслэлийн төр, захиргааны байгууллагын төлөөлөл, ЖАЙКА -ын Монгол дахь Төлөөлөгчийн газар зэрэг холбогдох талууд оролцож, төслийн үйл ажиллагааны явц, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргана.

Тус төсөл нь Дэлхийн банкны УБЦАТ, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын хандивлагч байгууллагатай уялдаатай хамтран ажиллахын зэрэгцээ ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж буй төрөл бүрийн тусламж, хамтын ажиллагааны нийтлэг үр дүнг сайжруулахад хувь нэмэр оруулна.



Зураг 3: Төслийн бүтэц, зохион байгуулалт

Хүснэгт 2: Хамтарсан Зохицуулах Хороо (ХЗХ)-ны гишүүд

| Дарга: Нийслэлийн Засаг даргын орлогч | | | |
|--|--|---------------------------------|--------------------------------|
| Дэд дарга: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга | | | |
| Нарийн бичиг: Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын дарга | | | |
| | Монгол тал | Япон тал | |
| 1 | Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын алба | ЖАЙКА-ын | Монгол дахь Төлөөлөгчийн газар |
| 2 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Түлшний бодлогын газар | ЖАЙКА-ын төв оффис (Токио хот) | |
| 3 | Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын Зээл, тусламжийн бодлогын хэлтэс | ЖАЙКА-ын мэргэжилтний баг | |
| 4 | Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн хэлтэс | ЖАЙКА-ын бусад холбогдох талууд | |
| 5 | Барилга, хот байгуулалтын яамны Бодлого төлөвлөлтийн газар | | |
| 6 | Эрчим хүчний яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | | |
| 7 | Цаг уур, орчны шинжилгээний газар | | |
| 8 | Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар | | |
| 9 | Нийслэлийн Тээврийн газар | | |
| 10 | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Агаарын чанарын хяналтын хэлтэс | | |
| 11 | Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс | | |
| 12 | УБ хотын ЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэс | | |
| 13 | Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори | | |
| 14 | ДЦС 3-ын техникийн бодлогын хэлтэс | | |
| 15 | ДЦС 4-ын техникийн бодлогын хэлтэс | | |